

# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн хуралдааны 04 дүгээр тэмдэглэлд:

"VI.ХЭЛЭЛЦСЭН нь: Монгол Улс, Дэлхийн банкны Олон улсын хөгжлийн ассоциаци хооронд байгуулсан "Ухаалаг засаг-2 төсөл"-ийн Зээлийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төсөл

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Монгол Улс, Дэлхийн банкны Олон улсын хөгжлийн ассоциаци хооронд байгуулсан "Ухаалаг засаг-2 төсөл"-ийн Зээлийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцээд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 21.1-д заасны дагуу нэн яаралтай хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтов." гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР